

# УЛААНБААТАР ХОТЫН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛАГЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТЭГШ БАЙДЛЫН СУДАЛГАА

Г.Өлзийсайхан, доктор, МУБИС  
Б.Оргилбаяр, Дорноговь 5-р сургууль

**Abstract:** Aim of this survey is studied an equity of kindergarten expenditures in Ulaanbaatar. We used statistic data and financial report from 2014 and there is included 163 kindergartens in order to study expenditure per child and its equity. The survey is conducted within equity indexes such as Verstegen index, Mcloone index and coefficient of variation and divided into two levels as all and districts. According to the survey result, an equity analysis of kindergarten expenditures per child is not equal to all kindergartens. However, expenditure per child is equal to all high expenditure kindergartens. Operational expenditure is divided into two expenditures such as variable and constant. According to this, all kindergartens and low expenditure kindergartens could not supply equality. According to the survey result of employment costs, all kindergartens and low expenditure kindergartens could not supply equality. Constant expenditure is not equal to all kindergartens, low and high expenditure kindergartens too. There is also inequality in district all districts without Baganuur district. Although, there is also inequality expenditure per child is equal to low expenditure kindergartens in Bayanzurkh and Khan-Uul district. There is also inequality expenditure per child is equal to low expenditure kindergartens in all district.

**Түлхүүр үг:** хүүхдийн цэцэрлэг, төсвийн зардал, тэгш байдал, нэг хүүхдэд ногдох зардал

## Удиртгал

Монгол улс шилжилтийн жилүүдэд боловсролын салбарт ихэд анхаарч, олон шинэчлэлийг хэрэгжүүлж ирлээ. Сургуулийн өмнөх боловсролд энэхүү шинэчлэл хэрэгжиж байна. Төрөөс боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх талаарх бодлогуудыг хэрэгжүүлсний дүнд цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо нэмэгдэж 2010 онтой харьцуулахад хамран сургалт 10.7 хувиар өсөж 2015 онд 82.9 хувьд хүрсэн байна (БСШУЯ, 2015, х.10). Энэ нь манай улс дэлхийн бусад орнуудтай харьцуулахад сургуулийн өмнөх боловсролд илүү их анхаарал хандуулдагийн илрэл бөгөөд тиймдээ ч сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг төрөөс санхүүжүүлж ирсэн байна.

Боловсролын төсөв нь боловсролын үйлчилгээг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бөгөөд боловсролын чанарт нөлөөлдөг чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Боловсролын үйлчилгээг нийтэд хүргэхийн тулд төсвийн бүрдүүлэлтийн баталгаатай байдлаас гадна бас төсвийн хуваарилалт чухал байдаг. Тиймээс ч боловсролын санхүүгийн асуудлаар бүрдүүлэлт, төсвийн хуваарилалт гэсэн хоёр чиглэлээр судалгаа хийгддэг ч хуваарилалтын дор нэгтгэн судлах хандлага байдаг (Кун, Чоно<sup>1</sup>, 1989, х.33). Боловсролын төсвийн хуваарилалтын

зарчмуудад тэгш байдал, үр ашиг, хангалттай байдал багтдаг. Үүнээс тэгш байдал гэдэг нь өгөгдсөн нөөцийг ямар нэг ялгаагүйгээр тэнцүү хуваарилахыг хэлнэ. Төсвийн тэгш бус хуваарилалт нь боловсролын ялгааг бий болгодог нэг хүчин зүйл юм. Тийм учраас гадаад орнуудад боловсролын төсвийн тэгш хуваарилалтын талаарх судалгаа тасралтгүй хийгдэж байна.

2013-2015 оны дунджаар манай улсын төсвийн орлогод боловсролын салбарын төсвийн эзлэх хувь 15.4, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 5.2 хувь (БСШУЯ, 2015, х.6) байгаа нь бүс нутагтаа харьцангуй өндөр үзүүлэлт юм (Якоб, Аннализа, Гэрэлмаа, 2014, х.23). 2014 оны байдлаар манай улсын төсвийн 90 хувийг зөвхөн татварын орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн байна (Сангийн Яам, 2013, х.9).

Манай улс татварын орлогоос бүрдсэн улсын төсвөөс боловсролын салбарыг санхүүжүүлдэг учир төсвийн хуваарилалтын тэгш байдал бол анхаарал хандуулах чухал асуудлын нэг юм. Манай улсын боловсролын санхүүжилтийн тэгш байдлыг судалсан судалгаанууд байдаг. Тухайлбал Дэлхийн банк (2006), Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг (2013а), Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг (2013б), Өлзийсайхан (2013)<sup>2</sup>, Якоб бусад

(2014) зэрэг судалгаанууд хийгдсэн ч эдгээр нь ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтээр хязгаарлагдаж байна. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүжилт, түүний дотор санхүүжилтийн тэгш байдлыг судалсан судалгаа хангалтгүй түвшинд байна. Иймээс энэхүү судалгаа нь хүүхдийн цэцэрлэгийн санхүүжилтийн тэгш байдал ямар түвшинд байгааг санхүүгийн бодит санд үндэслэн Улаанбаатар хотын хэмжээнд судлахыг зорилоо. Хөдөө орон нутгийн хүүхдийн цэцэрлэгүүдтэй харьцуулахад гадаад, дотоод нөхцөл байдал харьцангуй ижил түвшинд байдаг гэж үзсэний үндсэн дээр Улаанбаатар хотыг сонгож авлаа.

### **Боловсролын төсвийн хуваарилалтын тэгш байдал**

Төсвийн хуваарилалтын тэгш байдал зөвхөн боловсролын салбар төдийгүй бусад салбаруудад ч чухлаар хөндөгддөг чухал асуудал юм. Энэ нь нөөцийн дахин хуваарилалт нийгэмд хэр тэгш байгааг илэрхийлдэг. Боловсролын төсвийн хуваарилалтын тэгш байдлыг судлах болсон нь нэг сурагчид ижил хэмжээний зардал зарцуулах ёстой гэсэн энгийн санаанаас эхлэлтэй. Өөрөөр хэлбэл тэгш байдал хангагдана гэдэг нь орон нутаг, нийгмийн гарал, сургуулийн өмчийн хэлбэр зэрэг гадаад хүчин зүйлээр суралцагчийг ялгаварлах ёсгүйг чухалчилдаг.

Боловсролын төсвийн хуваарилалт тэгш бус байгааг олон тооны судалгаа гаргаж байсан ч Америкт үүссэн ‘Серрано ба Приест’<sup>3</sup> болон ‘Сан Антонио ба Родригюз’<sup>4</sup> маргаануудаас хойш төсвийн хуваарилалтын тэгш байдлын тухай асуудал улам чухалд тооцогдож ирсэн (Гармс, Гүдре & Прийсе<sup>5</sup>, 1978, х.38-39). 1971 онд Калифорни мужийн дээд шүүх ‘Серрано ба Приест’ хэргийг авч хэлэлцэн хөрөнгийн татварт суурилсан тус мужийн боловсролын санхүүжилтийн систем нь АНУ-ын Үндсэн хуулийн 14-р зүйлд заасан тэгш байдлын зарчмыг зөрчсөн гэж үзэн мужийн Засгийн газар боловсролын санхүүжилтийг олгоход орон нутгийн хөрөнгийн татвар бус харин мужийн хөрөнгийн татварт тулгуурлах ёстой гэсэн шийдвэрийг гаргажээ. Энэ нь АНУ-ын боловсролын системийг ганхуулсан шийдвэр байсан бөгөөд бүх муж боловсролын санхүүгийн системээ өөрчилжээ. Харин хоёр жилийн дараа буюу 1973 онд Нэгдсэн улсын Дээд шүүх ‘Сан Антонио ба Родригюз’ хэргийг авч хэлэлцэн Нэгдсэн улсын Үндсэн хуульд зааснаар

боловсрол нь үндсэн эрх биш учир хөрөнгийн татварт суурилсан тухайн үеийн боловсролын санхүүжилтийн систем Үндсэн хуульд нийцэхгүй гэсэн шийдвэр гаргасан нь ‘Серрано ба Приест’ хэргийн шийдвэрээс эсрэг шийдвэр байв. Хэдийгээр ‘Сан Антонио ба Родригюз’ хэргийн шийдвэрийн дараагаар АНУ хөрөнгийн татварт суурилсан боловсролын санхүүжилтийн системээ хэвээр хадгалж үлдсэн ч ихэнх муж дээрх хоёр шүүхийн шийдвэрийн дараагаар сургуулийн дүүрэг<sup>6</sup> хоорондын төсвийн санхүүжилтийн ялгаанд анхаарал хандуулах болжээ.

Боловсролын төсвийн хуваарилалтын тэгш байдал нь боловсролын үйлчилгээ ямар нэг байдлаар дутагдаж байгаа хүүхдэд илүү их зардлыг хуваарилах хэрэгтэй, үүнээс үүсэх тэгш бус байдал нь байж болох зүйл гэж үздэг. Ер нь санхүүжилтийн тэгш байдлыг судлахдаа хэвтээ чиглэлд тэгш байдлыг хангах, босоо чиглэлд тэгш байдлыг хангах<sup>7</sup> гэж хоёр ангилдаг. Хэвтээ чиглэлд тэгш байдлыг хангах гэдэг нь амьдралын нэг ижил нөхцөл байдалд байгаа хүмүүст ижил хандах ёстой<sup>8</sup>, босоо чиглэлд тэгш байдлыг хангах гэдэг нь амьдралын харилцан адилгүй нөхцөл байдалд байгаа хүмүүст ялгаатай хандах ёстой<sup>9</sup> гэсэн зарчим юм (Берне & Стифил<sup>10</sup>, 1994, х.406). Босоо чиглэлд тэгш байдлыг хангахад амьдралын харилцан адилгүй нөхцөл байдал гэдгийг юу гэж үзэх вэ гэдэг нь цаанаа үнэлэмж<sup>11</sup>-тэй холбоотой төвөгтэй асуудал юм. Гэсэн ч амьдралын харилцан адилгүй нөхцөл байдалд сурагчийн онцлог (хөгжлийн онцлог, гэр бүлийн орчин), бүс, орон нутгийн онцлог (газар зүйн байршил), хөтөлбөрийн онцлог (бага, дунд, ахлах, мэргэжлийн, гүнзгийрүүлсэн)-ийг дурьдаж болно (Одден<sup>12</sup>, 2000, х.477).

Манай улс сургуулийн өмнөх боловсролын төсвийг зардлын зүйлээс хамаарч үйл ажиллагааны зардлаар, санхүүжилтийн томъёо ашиглан, эрэлтэд суурилан санхүүжүүлдэг. Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилтийн эрх зүйн үндэс нь Боловсролын тухай хууль юм. Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлд “төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн төсөв нь улсын төсөв, эцэг, эх, асран хамгаалагчаас өгөх төлбөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ” гэж заасан байдаг.

6 school district

7 Үүнийг бас адил тэгш боловсрол олгох, боловсролыг тэгш олгох гэж нэрлэж болох юм.

8 equal treatment of equals

9 unequal treatment of unequals

10 Berne & Stiefel

11 value judgment

12 Odden

3 *Serrano v. Priest*

4 *San Antonio v. Rodriguez*

5 *Garms, Guthrie & Priece*

Улсын төсвөөс санхүүжих дүнд тогтмол зардал, хүүхдийн хоолны зардал, сургалтын норматив зардлууд багтана. Тогтмол зардлыг үйл ажиллагааны зардлаар буюу өмнөх жилийн гүйцэтгэлд тулгуурлан, хоолны болон хувьсах зардлыг хүүхдийн тоонд тулгуурлан нэг хүүхдэд ногдох норматив зардлаар, харин нэг удаагийн тэтгэмж зэрэг цөөн тооны зардлыг эрэлтэд тулгуурлан санхүүжүүлдэг. Норматив зардлыг Засгийн газрын тогтоолоор жил бүр баталсан жишгийн дагуу тооцож санхүүжүүлэх журамтай. Одоогийн мөрдөгдөж буй тогтоолоор хүүхдийн цэцэрлэгийн норматив зардал нь амьдралын нөхцөл байдлыг зөвхөн бүс нутгаар харгалзан үзсэн байдаг. Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын цэцэрлэгийг хамрах учир зөвхөн хэвтээ чиглэлд тэгш байдлыг хангаж буй эсэхийг судласан.

**Судалгааны арга зүй, үр дүн  
Судалгааны өгөгдөл**

Энэ судалгаа сургуулийн өмнөх боловсролын

төсвийн хуваарилалтын тэгш байдлыг судлах зорилготой. Уг зорилгын хүрээнд Улаанбаатар хотын төрийн өмчийн цэцэрлэгүүдийн төсвийн хуваарилалтын тэгш байдлыг суллаав.

Судалгаанд ашиглах өгөгдлийг цуглуулахын тулд БСШУЯ-нд хандан сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас гаргадаг СӨБ-1 (хүүхдийн тоо), СӨБ-6 (санхүүгийн тайлан) маягт бүхий 2014-2015 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг авч, боловсруулалт хийлээ. Улаанбаатар хотын нийт цэцэрлэгүүдээс ясли, асрамжийн, сувилалын цэцэрлэгүүдийг судалгаанд хамруулаагүй. Мөн зарим тоон үзүүлэлт бодит байдалд огт нийцэхгүй зарим цэцэрлэгийг энэхүү судалгааны дүнд дурдаагүй билээ. Цэцэрлэгийн хүүхдийн тоог зөвхөн өдрийн ангийн хүүхдийн тоогоор авсан бөгөөд санхүүгийн тайлан нь 2014 оны тайлан болно. Судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн мэдээллийг Хүснэгт 1-д харуулав. Улаанбаатар хотын төрийн өмчийн нийт 180 цэцэрлэгээс 163 цэцэрлэг буюу 90.6 хувийг судалгаанд хамруулаа.

**Хүснэгт 1**

Судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн тоо /2014-2015 оны хичээлийн жил/

Дүүрэг	Цэцэрлэгийн тоо /төрийн/	Судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн тоо /төрийн/	Эзлэх хувь
Баянгол	29	27	93.1
Баянзүрх	30	26	86.7
Сүхбаатар	26	25	96.2
Сонгинохайрхан	37	35	94.6
Чингэлтэй	23	21	91.3
Хан-Уул	23	18	78.3
Налайх	6	5	83.3
Багануур	5	5	100
Багахангай	1	1	100
Нийт	180	163	90.6

**Судалгааны арга**

Боловсролын салбар дахь төсвийн хуваарилалтын тэгш байдлыг судлахдаа нэг хүүхдэд ногдох зардал тэгш байдлыг хангаж буй эсэхийг судалдаг. Бид энэхүү судалгаандаа мөн адил нэг хүүхдэд ногдох зардлын хэвтээ чиглэл дэх тэгш байдлыг судаллаа.

Боловсролын төсвийн хуваарилалт хэвтээ чиглэлд тэгш байдлыг хангаж буй эсэхийг судлахад ашигладаг олон аргууд байдаг ч энэ судалгаанд хамгийн их утга, хамгийн бага утга, вариацийн коэффициент<sup>1</sup>, Маклүүний индекс<sup>2</sup>,

Верстегений индекс<sup>3</sup>-ийг ашиглалаа. Эдгээрийн тайлбарыг доор харуулав.

Нэг хүүхдэд ногдох зардлыг тооцоолон хамгийн их ба хамгийн бага утгыг олно. Энэ хоёр утгын ялгаа их байх тусам тэгш бус байдал их байна гэж үздэг. Энэ нь зөвхөн хоёр тоон утгыг харьцуулдаг учир тэгш байдлыг нийт түүврийн хүрээнд авч үзэхэд хангалтгүй юм.

Нэг хүүхдэд ногдох зардлын тэгш байдлыг хэмждэг өөр нэг индекс бол вариацийн коэффициент юм. Энэ нь түүврийн нэг хүүхдэд ногдох зардлын стандарт хазайлтыг, түүврийн нэг хүүхдэд ногдох дундаж зардалд харьцуулсан утга

<sup>1</sup> coefficient of variation, CV

<sup>2</sup> McLoone Index

<sup>3</sup> Verstegen Index

бөгөөд 0-ээс 1 гэсэн утгыг авдаг. 0 утгад ойртох тусам тэгш байдлыг хангаж байна гэж үздэг. Яг ямар утга авбал тэгш байдлыг хангана гэж үзэх нь тийм хялбар зүйл биш ч судалгаануудаас харахад

0.1 утгаас доош тохиолдолд тэгш байдлын хангаж байна гэж үздэг тул энэ судалгаанд мөн энэ жишгийг баримтлав. Вариацийн коэффициентыг дараах томъёогоор тооцоолдог.

$$C = \frac{\sqrt{\frac{\sum_{i=1}^N P_i (X_i - \bar{X})^2}{\sum_{i=1}^N P_i}}}{\bar{X}} \text{ ----- } \langle \text{томъёо 1} \rangle$$

- ☐ – i дүгээр цэцэрлэгийн хүүхдийн тоо
- i дүгээр цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох зардал
- нийт цэцэрлэгүүдийн нэг хүүхдэд ногдох зардлын дундаж
- хүүхдийн цэцэрлэгийн тоо

Төсвийн хуваарилалтын тэгш байдлыг хэмжихэд боловсролын салбарт өргөн ашигладаг өөр нэг индекс бол Маклүүний индекс юм. Маклүүний индекс нь нэг хүүхдэд ногдох зардал түүврийн нэг хүүхдэд ногдох зардлын медиан утгаас бага байгаа цэцэрлэгийн бүлэгт тэгш байдлыг судалдаг. Энэ нь уг бүлгийн зардлын нийлбэрийг эдгээр цэцэрлэгүүд медиан утгатай

адил зардал гаргасан байх нийлбэрт хуваасан утга юм. Маклүүний индекс 0-ээс 1-ийн хоорондох утгыг авна. 1 утгыг авбал тэгш байдал бүрэн хангагдаж байна гэж үзэж, 0.90-аас их утга авбал тэгш байдлыг хангаж байна гэж үздэг. Харин 0.80-аас бага утга авбал тэгш бус байдал маш их байна гэж үзнэ.

$$M = \frac{\sum_{i=1}^k X_i P_i}{M_p \sum_{i=1}^k P_i} \text{ ----- } \langle \text{томъёо 2} \rangle$$

- ☐ – нэг хүүхдэд ногдох зардлын медиан утга
- i дүгээр сургуулийн хүүхдийн тоо
- i дүгээр сургуулийн нэг хүүхдэд ногдох зардал
- медиан утгад харгалзах сургуулийн дугаар

Верстегений индекс нь нэг хүүхдэд ногдох зардал түүврийн нэг хүүхдэд ногдох зардлын медиан утгаас их цэцэрлэгийн бүлэгт тэгш байдал ямар байгааг илэрхийлдэг. Уг бүлгийн зардлын нийлбэрийг тухайн цэцэрлэгүүд медиан утгатай адил зардал гаргасан гэж тооцсон нийлбэрт хуваасан утга юм. Энэ утга нь 1-ээс их утга авах

ба 1-тэй тэнцүү бол тэгш байдлын бүрэн хангана гэж үздэг боловч 1.1-ээс бага утга авбал тэгш байдлыг хангаж байна гэж үздэг. Харин 1.2-оос их утга авбал тэгш бус байдал их байна гэж үздэг. Верстегений индексийг дараах томъёогоор тооцоолдог.

$$V = \frac{\sum_{j=k}^N X_{j+1} P_{j+1}}{M_p \sum_{j=k}^N P_{j+1}} \text{ ----- } \langle \text{томъёо 3} \rangle$$

- ☐ – нэг хүүхдэд ногдох зардлын медиан утга
- j дүгээр сургуулийн хүүхдийн тоо
- j дүгээр сургуулийн нэг хүүхдэд ногдох зардал
- медиан утгад харгалзах сургуулийн дугаар
- хүүхдийн цэцэрлэгийн тоо

### Үр дүн

Энэхүү судалгаагаар нэг хүүхдэд ногдох зардлаар төлөөлүүлэн сургуулийн өмнөх боловсролын төсвийн санхүүжилтийн тэгш байдлыг Улаанбаатар хот, дүүрэг гэсэн хоёр түвшинд судаллаа. Судалгааны үр дүнг хүснэгт 2-6-д харуулав.

Улаанбаатар хотын цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал зардлын тэгш байдлыг судалсан үр дүнг Хүснэгт 2-г харууллаа. Улаанбаатар хотын цэцэрлэгүүд 2014 онд дундажаар нэг хүүхдэд 1,093,938 төгрөг зарцуулсан байна. Улаанбаатар

хотын нэг хүүхдэд ногдох урсгал зардлын тэгш байдлыг судлахад вариацийн коэффициент 0.194 буюу тэгш байдлыг хангаагүй гэсэн үзүүлэлт гарлаа. Нэг хүүхдэд ногдох урсгал зардал медиан утгаас бага цэцэрлэгийн бүлэг (цаашид бага зардалтай цэцэрлэгийн бүлэг гэж нэрлэе)-г урсгал

зардлын тэгш байдлыг судлахад Маклүүний индекс 0.881 буюу тэгш бус гэж гарсан бол медиан утгаас их цэцэрлэгийн бүлэг (цаашид их зардалтай цэцэрлэгийн бүлэг гэж нэрлэе)-г Верстегений индекс 0.768 гарч тэгш байдлыг хангасан байна.

**Хүснэгт 2**  
Урсгал зардлын тэгш байдлын судалгаа

	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/
Дундаж	1,093,938
Хамгийн бага утга	746,914
Хамгийн их утга	2,702,377
Вариацийн коэффициент (CV)	0.194
Маклүүний индекс	0.881
Верстегений индекс	0.768

Тэгш байдлыг хангах нөхцөл:  $CV \leq 0.1$ ;  $McLoone\ Index \geq 0.9$ ;  $Verstegen\ Index \leq 1.1$

Урсгал зардлыг дотор нь хувьсах зардал, тогтмол зардал гэж ангилан тэгш байдлыг судалсан үр дүнг Хүснэгт 3, 4-г харууллаа.

Улаанбаатар хотын хүүхдийн цэцэрлэгүүд 2014 онд нэг хүүхдэд дунджаар 748,153 төгрөгийн хувьсах зардал зарцуулсан байна. Хувьсах зардлын тэгш байдлыг судлахад вариацийн коэффициент 0.215 гарч санхүүжилт тэгш бус гэсэн үр дүн гарч

байна. Бага зардал (хувьсах зардлаар тооцоход)-тай цэцэрлэгийн бүлэгт тэгш байдлыг судалж үзэхэд Маклүүний индекс 0.874 гарч тэгш байдлыг хангаагүй байна. Их зардал (хувьсах зардлаар тооцоход)-тай цэцэрлэгийн бүлэгт Верстегений индекс 0.702 буюу тэгш байдал хангагдсан гарч байна.

**Хүснэгт 3**  
Хувьсах зардлын тэгш байдлын судалгаа

	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/
Дундаж	748,153
Хамгийн бага утга	496,855
Хамгийн их утга	2,104,491
Вариацийн коэффициент (CV)	0.215
Маклүүний индекс	0.874
Верстегений индекс	0.702

Тэгш байдлыг хангах нөхцөл:  $CV \leq 0.1$ ;  $McLoone\ Index \geq 0.9$ ;  $Verstegen\ Index \leq 1.1$

Улаанбаатар хотын цэцэрлэгүүд 2014 онд нэг хүүхдэд дундажаар 91,628 төгрөгийн тогтмол зардал зарцуулжээ. Улаанбаатар хотын хэмжээнд тэгш байдлыг судлахад вариацийн коэффициент 0.505 гарч санхүүжилт тэгш бус байгааг харууллаа. Бага зардал (тогтмол зардлаар

тооцоход)-тай цэцэрлэгийн бүлэгт тэгш байдлыг судлахад Маклүүний индекс 0.780 буюу тэгш бус гарч байна. Их зардал (тогтмол зардлаар тооцоход)-тай цэцэрлэгийн бүлэгт Верстегений индекс 1.468 буюу тогтмол зардлын санхүүжилт тэгш бус гэсэн үр дүн гарч байна.

**Хүснэгт 4**  
Тогтмол зардлын тэгш байдлын судалгаа

	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/
Дундаж	91,628
Хамгийн бага утга	24,568
Хамгийн их утга	292,063
Вариацийн коэффициент /CV/	0.505
Маклүүний индекс	0.780
Верстегений индекс	1.468

Тэгш байдлыг хангах нөхцөл:  $CV \leq 0.1$ ;  $McLoone\ Index \geq 0.9$ ;  $Verstegen\ Index \leq 1.1$

Хувьсах зардлаас цалингийн зардлыг салган авч нэг хүүхдэд ногдох цалингийн зардлын тэгш байдлыг судалсан үр дүнг Хүснэгт 5-д харуулав. Нэг хүүхдэд ногдох цалингийн зардлын дундаж 719,835 төгрөг байна. Цалингийн зардлын тэгш байдлыг судлахад вариацийн коэффициент 0.210 гарч санхүүжилт тэгш бус гэсэн үр дүн гарч

байна. Нэг хүүхдэд ногдох цалингийн зардал бага цэцэрлэгийн бүлэгт Маклүүний индекс 0.882 буюу тэгш бус үзүүлэлттэй. Харин нэг хүүхдэд ногдох цалингийн зардал ихтэй цэцэрлэгийн бүлэгт Верстегений индекс 0.714 буюу цалингийн зардлын санхүүжилт тэгш байдлыг хангасан үр дүн гарчээ.

**Хүснэгт 5**  
Цалингийн зардлын тэгш байдлын судалгаа

	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/
Дундаж	719,835
Хамгийн бага утга	484,459
Хамгийн их утга	1,946,736
Вариацийн коэффициент (CV)	0.210
Маклүүний индекс	0.882
Верстегений индекс	0.714

Тэгш байдлыг хангах нөхцөл:  $CV \leq 0.1$ ;  $McLoone\ Index \geq 0.9$ ;  $Verstegen\ Index \leq 1.1$

Дүүрэг доторх нэг хүүхдэд ногдох урсгал зардлын тэгш байдлыг судлахад вариацийн коэффициент 0.117 гарч тэгш байдлыг хангаагүй гарсан ч тэгш байдлыг хангахад дөхсөн үзүүлэлттэй байна. Дүүрэг доторх нэг хүүхдэд ногдох урсгал зардлын дундаж нь Багануур, Налайх дүүргүүд хамгийн их, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг хамгийн бага байна. Дүүрэг

дотор тэгш бус байдлыг судлахад Багануур дүүргээс бусад дүүрэгт тэгш бус байдалтай гарч байна. Харин бага зардалтай цэцэрлэгийн бүлэг, их зардалтай цэцэрлэгийн бүлэгт тэгш байдал ямар байгааг судлахад тэгш байдлыг хангасан үр дүн гарч байна. Зөвхөн Баянзүрх, Хан-Уул дүүргийн бага зардалтай бүлэг тэгш байдлыг хангаж чадахгүй байна.

**Хүснэгт 6**  
Дүүрэг доторх тэгш байдлын судалгаа (нийт урсгал зардлын)

Дүүрэг	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/			Вариацийн коэффициент (CV)	Маклүүний индекс	Верстегений индекс
	Дундаж	Хамгийн бага утга	Хамгийн их утга			
Баянгол	1,143,142	889,319	2,702,377	0.200	0.950	0.727
Баянзүрх	1,084,747	825,661	2,010,523	0.190	0.898	0.731
Сүхбаатар	1,123,005	868,388	1,706,133	0.162	0.906	0.621
Сонгинохайрхан	1,268,351	891,761	2,034,484	0.170	0.907	0.775
Чингэлтэй	1,096,782	889,532	1,723,404	0.153	0.944	0.783
Хан-Уул	1,085,746	746,914	1,413,552	0.189	0.831	0.596
Налайх	1,356,158	1,221,463	1,623,530	0.115	0.976	0.963
Багануур	1,396,473	1,259,886	1,501,062	0.061	0.936	1.026

Тэгш байдлыг хангах нөхцөл:  $CV \leq 0.1$ ;  $McLoone\ Index \geq 0.9$ ;  $Verstegen\ Index \leq 1.1$

\* Багахангай дүүрэг нэг цэцэрлэгтэй тул дүүрэг доторх тэгш байдлыг тодорхойлох боломжгүй

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын цэцэрлэгийн санхүүжилтийн тэгш байдалд 2014 онд нэг хүүхдэд ногдох зардлаар төлөөлүүлэн анализ хийж, судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэг, зардлын төрлүүдийг урсгал зардал, хувьсах зардал, цалингийн зардал, тогтмол зардал гэж ангилан тэгш байдлыг судлахад Улаанбаатар хотын хэмжээнд тэгш байдлыг хангаагүй гэсэн үзүүлэлт гарч байна. Харин нэг хүүхдэд ногдох зардал их цэцэрлэгийн бүлэгт тэгш байдал хангагдаж байна. Гэтэл нэг хүүхдэд ногдох зардал бага цэцэрлэгийн бүлэгт тэгш байдал хангалтгүй байна. Энэ нь нэг хүүхдэд ногдох зардал их бүлэгт багтах цэцэрлэгүүдийн хооронд ялгаа бага ч бага зардалтай бүлэгт багтах цэцэрлэгүүдийн хооронд ялгаа их байгааг харуулж байна. Улаанбаатар хотын цэцэрлэгийн хувьсах зардал нь Засгийн газрын тогтоолоор нэг хүүхдэд ногдох норматив зардлаар тогтоогдох ёстой. Гэтэл зарцуулалтын тэгш байдлыг судлахад үүнээс эсрэг үр дүн гарч байгаа нь цаашид норматив зардлын жишгийг өөрчлөх, эсвэл зарцуулалтын хяналтыг сайжруулах арга хэмжээ авах хэрэгтэй гэдгийг харуулж байна.

Энэхүү судалгаанд ашигласан тэгш байдлын шалгуур индексүүд нь харьцангуй ойлголт хэдий ч тогтмол зардал нь бусад зардалтай харьцуулахад тэгш бус байдал хэт их байна. Тогтмол зардал нь барилга, байгууламжийн онцлогоос хамаардаг тул судалгааны үр дүнд болгоомжтой хандах хэрэгтэй. Гэсэн хэдий ч тэгш байдлын зарчмыг хангахын тулд цаашид тогтмол зардлыг нарийвчлан судлах шаардлагатай.

Хоёр, дүүрэг доторх нэг хүүхдэд ногдох урсгал зардлын тэгш байдлыг судалж үзэхэд зөвхөн Багануур дүүрэгт тэгш байдал хангагдсан байна. Харин бүх дүүргүүдэд нэг хүүхдэд ногдох зардал ихтэй, зардал багатай цэцэрлэгийн бүлэгт тэгш байдал хангагдсан үзүүлэлттэй байна. Энэ нь цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал зардлын зарцуулалт дээрх хоёр бүлгийн хувьд маш их зөрүүтэйг харуулж байна. Цаашид Улаанбаатар хотын цэцэрлэгүүдийн төсвийн тэгш байдлыг хангах арга хэмжээг авахдаа дээрх хоёр бүлгийн ялгааг ч мөн адил багасгах шаардлагатай нь харагдаж байна.

Цаашид боловсролын бодлогод нөлөөлөхүйц судалгаануудыг тасралтгүй хийх хэрэгцээний үүднээс энэхүү судалгаа Улаанбаатар хотын төрийн өмчийн цэцэрлэгүүдийн төсвийн санхүүжилтийн тэгш байдлыг судаллаа. Улсын

түвшинд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төсвийн хуваарилалтын тэгш байдлыг судалгаа хийх хэрэгтэй байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- БСШУЯ. (2015). Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын төсвийн танилцуулга. Хурлын материал.
- Заяадэлгэр, А. (2011). *Боловсролын эдийн засаг*. УБ: Мөнхийн үсэг.
- Сангийн Яам (2013). Монгол улсын 2014 оны нэгдсэн төсөв. from: <https://mof.gov.mn/wp-content/uploads/2013/12/2014-tosov-comics-last-4.pdf>
- Якоб, Энгель., Аннализа, Прицон. & Гэрэлмээ, А. (2014). Уналтаас сэргэлтэд: Монгол улсын багаас дээш шатны боловсрол. Хөгжлийн ахиц дэвшил. from [http://www.developmentprogress.org/sites/developmentprogress.org/files/case-study-summary/mongolia\\_-\\_translation\\_-\\_final.pdf](http://www.developmentprogress.org/sites/developmentprogress.org/files/case-study-summary/mongolia_-_translation_-_final.pdf)
- Bartlett, W., Byambatsogt, J. & Enkh-Amgalan, L. (2004). *Technical Assistance for Improved Education Expenditure in Mongolia Final report*. Washington, DC: World Bank.
- Berne, R. & Stiefel, L. (1994). Measuring Equity at the School Level: The Finance Perspective. *Educational Evaluation and Policy Analysis*, 16(4), 405-421.
- Garms, W. I., Guthrie, J. W., & Priece, L. C. (1978). *School Finance: The Economics and Politics of Public Education*. New-Jersey: Prentice-Hall.
- Odden, A. R. (2000). The New School Finance: Providing Adequacy and Improving Equity. *Journal of Education Finance*, 25(4), 467-487.
- Ulziisaikhan, G. (2013). An Equity Analysis of Mongolian Elementary and Secondary School Educational Finance. *Journal of Education of International Understanding*, 8(1), 25-56. In Korean.
- World Bank. (2006). *Public Financing of Education in Mongolia: Equity and efficiency implications*. Washington DC: World Bank.
- Kong Eun-Bea, Chun Se-Young (1989). *Comprehensive Diagnostic Study on Educational Investment Policy in Korea*. KEDI. In Korean.